



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 5/206

Хэрлэн сум

Л.Дугар, Ц.Ганчимэг нарыг шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.1, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны Тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Цэрэнпунцагийн Ганчимэг, Аж ахуйн тасгийн жижүүр Ламзавын Дугар нар нь Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 212 дугаар тогтоолоор “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагдсан тул тус бүр 200,000 (хоёр зуун мянган) төгрөгөөр шагнасугай.

2.Шагналын зардалд зарцуулах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Ж.ГАНТУЛГА